



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 61/18

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өлгий” нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын өргөтгөлийн барилгын төсвийг шинэчлэн боловсруулах гэрээ” ИНЕГ/ШГ/03/22 дугаартай ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

С.Нацагдорж

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх  
буудлуудын үйлчилгээний газрын дарга)

Гишүүд:

Б.Амартүвшин

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны дарга)

Э.Мөнх-Эрдэнэ

(Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын  
навигаци, нисэх буудлын бодлого  
зохицуулалтын газрын аэродром  
хариуцсан мэргэжилтэн)

Г.Ууганцэрэн

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн  
үйлчилгээ, дулаан сантехникийн албаны  
Аж ахуй, барилга засварын хэсгийн  
барилгын инженер)

17120 0117

Нарийн бичгийн дарга:

Х.Рэнцэнпил

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны инженер)

2. Гэрээнд заасан ажлын даалгаврын дагуу ажлыг шалгаж хүлээн авах, комиссын дүгнэлт гаргах, санхүүгийн бүртгэлд тусгуулах холбогдох гүйцэтгэлийн баримт бичгийг бүрдүүлж, 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлэхийг ажил хүлээн авах комисс (С.Нацагдорж)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА